

“ХАН-УУЛ ЗАМ ЗАСВАР, АРЧЛАЛТ” ОНӨААТҮГ-ЫН 2024 ОНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 02

Улаанбаатар хот

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ “БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

1.1. Авто замын ачааллыг бууруулах чиглэлээр шинээр авто зам барьж, хороолол доторх авто замд засвар шинэчлэлт хийх ажил

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/88 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж Хан-Уул дүүргийн 12 дугаар хороо, 121 дүгээр цэцэрлэг орчмын 1,09км авто замын:

- Хөрс хуулалтын ажил-100%
- Ул хөрсний нягтруулалт-100%
- Авто замын үерийн ус зайлуулах 900м урт шугамын ажил-100%
- Авто замын трасст орсон Цахилгаан дамжуулах кабель шугам бүрэн шилжигдэж шинээр барих ажил-100%
- Авто замын трасст Мэдээлэл холбооны кабель шилжүүлэг-100%
- Явган хүний зам
- Авто замын гэрэлтүүлэг
- Өнгө хучилт

Төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэх ажлууд:

Тус авто замын үлдсэн 100 метр газарт ЦДАШ, ЦДКШ, гэрэлтүүлгийн ажлыг гүйцэтгэгч байгууллага нь бүрэн хийж гүйцэтгээгүй тул 2025 онд бүрэн хийж Нийслэлийн замын хөгжлийн газарт хүлээлгэж өгөхөөр ажиллаж байна. Тус ажилд нийт 1,756,258,366₮ зарцуулсан. Ажлын гүйцэтгэл-80%



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/90 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангаж Хан-Уул дүүргийн 10 дугаар хороо, Морингийн 1 дүгээр гудамжнаас хойш шинээр хийгдсэн төв замын төгсгөлтэй холбогдох 710метр авто замын

- Хөрс хуулалтын ажил-100%
- Ул хөрсний нягтруулалт-100%
- Хөлдөлтөөс хамгаалах үе бүрэн дэвсгэгдэж нягтруулах ажил-100%
- Авто замын трасст орсон Цахилгаан дамжуулах кабель шугам бүрэн шилжигдэж шинээр барих ажил-100%
- Авто замын гэрэлтүүлэг
- Явган хүний зам /Зүүн тал/
- Өнгө хучилт
- Босоо болон хэвтээ тэмдэг

Төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэх ажлууд:


Тус авто замын баруун талын явган хүний замын трасст 7 айл өрхийн хашаа орсон тул 7 айл өрхийн газрын үнэлгээг хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлж хашааг татаж шилжүүлэн явган замын трассыг чөлөөлж явган хүний замыг шинээр хийж гүйцэтгэн 2025 онд байнгын ашиглалтад хүлээлгэж өгнө. Тус ажилд нийт 1,085,365,011₮ төгрөгийг зарцуулсан байна. Ажлын гүйцэтгэл-80%



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/76 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж Хан-Уул дүүргийн 9 дүгээр хороо, Төм замаас Центрийн нүүрний гудамжинд хийгдэх 470метр авто замын ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн. Байнгын ашиглалтад хүлээлгэж өгөхөөр Нийслэлийн замын хөгжлийн газрын комиссыг ажиллуулахаар ажиллаж байна. Тус ажилд нийт 779,030,659₮ төгрөгийг зарцуулсан. Ажлын гүйцэтгэл-100%



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны А/191, А/343, А/524, А/649 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж Хан-Уул дүүргийн 1, 2, 3, 5, 6, 8, 10, 11, 15, 17, 19, 21, 23, 24, 25 дугаар хороодын орон сууц хороолол доторх авто зам болон туслах авто замын эвдрэл ихтэй хэсэгт нийт 3000м2 нөхөөсний ажлыг хийж гүйцэтгэхээс 10,000м2 нөхөөсийг хийж гүйцэтгэн төлөвлөгөөт ажлыг 3,3 дахин давуулан биелүүлж ажилласан. Тус ажилд нийт 1,007,071,475₮ төгрөгийг зарцуулсан. Ажлын гүйцэтгэл-100%



Байршил	17-р хороо
Хийгдэх ажил	Авто замын нөхөөсний ажил
Замалалч	Хан-Уул дүүрэг ЗДТГ
Гүйцэтгэгч	Хан-Уул зам засвар, арчлалт
Огноо	2024.07.01



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн А/602 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж Хан-Уул дүүргийн 20 дугаар хороо, Иргэдэд үйлчлэх төв байрны урд талын замын нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд авто замын суурийг буталсан чулуугаар нягт гаргаж халуун асфальтаар хучиж тус ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн.



1.2. Хан-Уул дүүргийн гэр хорооллын гудамж зам талбайг зохист найрлагатай хайргаар засварлах ажил

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/150 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж Хан-Уул дүүргийн 4 дүгээр хорооны

- Арцат 6 гудамж
- Арцат 7 гудамж
- Арцат 9 гудамж
- Арцат 9б гудамж
- Арцат 11 гудамж
- Арцат 11, 12 зааг гудамж
- Арцат 11, 14 гудамж дунд
- Арцат 17 гудамжны нийт 8 байршилд 16,980м² гудамж зам талбайг зохист найрлагатай хайргаар засварлах ажлыг бүрэн хийж гүйцэтгэн Хан-Уул дүүргийн Техник хяналтын коммист хүлээлгэн өгч ажилласан.



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/211 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангаж Хан-Уул дүүргийн 4, 5, 6, 7, 8 дугаар хороодын гэр хорооллын гудамж зам талбайн нийт 32 байршилд зохист найрлагатай хайргаар засварлах ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн. /Гүйцэтгэл-100%/



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/317 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж Хан-Уул дүүргийн 5, 9, 10, 16, 23, 25 дугаар хороодын гэр хорооллын нийт 20 гудамжны 56090м² зам талбайг зохист найрлагатай хайргаар бүрэн засварлаж техник хяналтын комисст хүлээлгэж өгсөн. /Гүйцэтгэл-100%/



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/367 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж Хан-Уул дүүргийн 9, 12, 13, 14 дүгээр хороодын гэр хорооллын гудамж зам талбайн нийт 20 байршилд зохист найрлагатай хайргаар засварлах ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн. /Гүйцэтгэл-100%/



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн А/572, А/573, А/574 дүгээр захирамжийн хэрэгжилтийн хангаж Хан-Уул дүүргийн 5, 6, 7, 8, 9, 10, 12, 13, 14, 16, 25 дугаар хороодын гэр хорооллын гудамж зам талбайг зохист найрлагатай хайргаар засварлах ажлын хүрээнд нийт 88 гудамж зам талбайг бүрэн засварлаж 2024 онд нийт 170 гудамжны 452,786м² зам талбайг зохист найрлагатай дайргаар засварлах ажлыг хийж гүйцэтгэсэн. Тус гэр хорооллын гудамж зам талбайг зохист найрлагатай хайргаар засварлах ажилд нийт 4,764,641,238₮ төгрөгийг зарцуулж 2024 оны төлөвлөгөөт ажлыг 2,9 дахин давуулан биелүүлж ажилласан.



1.3. Хан-Уул дүүргийн орон сууц хороолол доторх авто замд эгнээ тусгаарлагч, хурд сааруулагч, үерийн ус зайлуулах лотки суурилуулах, авто замын босоо болон хэвтээ тэмдэг тэмдэглэгээг сэргээн засварлах ажил

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/151 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангаж 2, 5, 10, 19, 21 дүгээр хороодын орон сууц хороолол доторх авто зам, сургууль цэцэрлэг орчмын бүсэд хүүхэд болон явган зорчигчийн эрүүл аюулгүй зорчих нөхцөлийг хангаж тус хороодын 21 байршилд 535ш хурд сааруулагч байршуулах ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн. /Гүйцэтгэл-100%/



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/169 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангаж Хан-Уул дүүргийн 20 дугаар хорооны “Эко зурвас” гүйлт, дугуйн замтай холбогдсон

- Явган хүний шат-/14 марштай төмөр шат/
- Налуу зам-/10.53м урт, өргөн 2м/
- Явган болон дугуйтай зорчих замыг зохист найрлагатай хайргаар засварласан-/220м3 зохист найрлага/
- Явган болон дугуйн замын хучилт-/388м2/ халуун асфальт бетон хольцоор хучих ажлыг бүрэн хийж гүйцэтгэн Хан-Уул дүүргийн Техник хяналтын коммист хүлээлгэн өгч ажилласан.



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/152 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж Хан-Уул дүүргийн 9 дүгээр хороо, 134 дүгээр цэцэрлэгийн гадна талбайд нийт 1000м2 буюу 10 машины авто зогсоол, ус шүүрүүлэх худаг, явган хүний замыг шинээр халуун асфальт бетон хольцоор бүрэн хийж гүйцэтгэн иргэд тээврийн хэрэгслийн аюулгүй зорчих, зогсох нөхцөлөөр хангаж ажилласан.



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/324 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангаж Хан-Уул дүүргийн 24 дүгээр хороо, Белмонте хотхон орчмын авто замын засварын ажлыг бүрэн хийж гүйцэтгэн шинээр явган хүний гарц, хурд сааруулагч болон босоо тэмдгийг суурилуулан иргэд, тээврийн хэрэгслийг эрүүл аюулгүй зорчих нөхцөлөөр хангаж ажилласан.



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/323 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж Хан-Уул дүүргийн орон сууц хороолол доторх авто замын хэвтээ тэмдэглэгээ сэргээх, шинээр хийх ажлыг 1, 2, 3, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 21, 23, 24 дүгээр хороодын нийт 142 байршилд шөнийн цагаар ажиллаж бүрэн хийж гүйцэтгэсэн. /Гүйцэтгэл-100%/



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн А/481 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангаж Хан-Уул дүүргийн 11, 20, 24 дүгээр хороодын туслах зам болон орон сууц хороолол доторх замд нийт 10 байршилд эгнээ тусгаарлагч, босоо тэмдгийг шинээр байршуулж тус ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн. /Гүйцэтгэл-100%/



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/525 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж Хан-Уул дүүргийн 1, 5, 6, 7, 8, 9, 13, 18, 20, 23 дугаар хороодын авто замын явган зам, авто замын гарцын хэвтээ тэмдэг, хурд сааруулагчийн хэвтээ тэмдэг, авто замын хэвтээ тэмдэгнүүдийг бүрэн сэргээн засварлаж ажилласан. /Гүйцэтгэл-100%/



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/342 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж Хан-Уул дүүргийн 8, 10, 12, 16, 19 дүгээр хороодын туслах болон орон сууц хороолол доторх авто замд нийт 108ш 5400м урт хурд сааруулагчийг шинээр байршуулж ажилласан.



Байршил	12-хороо 190-Цэцэрлэг хойд авто зам
Хийгдэх ажил	Хурд сааруулагч
Захиалагч	Хан уул дүүрэг ЗДТГ
Гүйцэтгэгч	Хан уул зам засвар арчлалт ОНБААТҮГ
Огноо	2024.11.04



Байршил	10-хороо 7-р байрний зүүн талын авто зам
Хийгдэх ажил	Хурд сааруулагч
Захиалагч	Хан уул дүүрэг ЗДТГ
Гүйцэтгэгч	Хан уул зам засвар арчлалт ОНБААТҮГ
Огноо	2024.11.05



Байршил	8-хороо 209-Цэцэрлэгийн баруун талд
Хийгдэх ажил	Хурд сааруулагч
Захиалагч	Хан уул дүүрэг ЗДТГ
Гүйцэтгэгч	Хан уул зам засвар арчлалт ОНБААТҮГ
Огноо	2024.10.29

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн А/477 дугаар захирамжийн хэрэгжилтийг Хан-Уул дүүргийн 9 дүгээр хорооны Буянт-Ухаа 23 дугаар гудамжны үерийн усанд угаагдаж иргэд болон тээврийн хэрэгсэл зорчиход хүндрэлтэй тус гудамж зам талбайг зохист найрлагатай хайргаар засварлаж нийт 116 метр үерийн ус зайлуулах лотки, 100 метр далан шуудуу, 62 метр ган туузан хашлагыг суулгах ажлуудын бүрэн хийж гүйцэтгэн зорчих хэсгийн хөдөлгөөнийг хэвийн нөхцөлд оруулж ажилласан. /Гүйцэтгэл-100%/



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/322 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж Хан-Уул дүүргийн 9 дүгээр хороо, үерийн усанд ихээр өртдөг Центрийн гудамжинд ус зайлуулах лотки-58м, шүүр тагтай лотки-12м, нийт 70м урт борооны үерийн ус зайлуулах лотки суурилуулах ажлыг бүрэн хийж гүйцэтгэж үерийн усны эрсдэлийг бууруулж ажилласан.



Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/696 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж Хан-Уул дүүргийн 1, 5, 10, 11, 15, 16, 17, 18, 20, 21 дүгээр хороодын сургууль цэцэрлэг орчмын авто замуудын нийт 26 байршилд нийт 317ш 15,850м урт хурд сааруулагчийг шинээр байршуулж ажилласан. Ажлын гүйцэтгэл-100%



Байршил	20-Хороо 80-байрны зүүн талын авто зам
Хийгдэх ажил	Хурд сааруулагч
Захиалагч	Хан уул дүүрэг ЗДТГ
Гүйцэтгэгч	Хан уул зам засвар арчлалт ОНБААТҮГ
Огноо	2024.11.12



Байршил	15-хороо Цэнгэлдэх хотхоны зүүн талын авто зам
Хийгдэх ажил	Хурд сааруулагч
Захиалагч	Хан уул дүүрэг ЗДТГ
Гүйцэтгэгч	Хан уул зам засвар арчлалт ОНБААТҮГ
Огноо	2024.11.12



Байршил	10-хороо 61-р байрны баруун талын авто зам
Хийгдэх ажил	Хурд сааруулагч
Захиалагч	Хан уул дүүрэг ЗДТГ
Гүйцэтгэгч	Хан уул зам засвар арчлалт ОНБААТҮГ
Огноо	2024.11.15

Хан-Уул дүүргийн 21 дүгээр хороо, Эх хүүхдийн эрүүл мэндийн нэгдсэн эмнэлгийн хойд талын авто замын ус зайлуулах шугамыг цэвэрлэж төмөр тагыг бетон тагаар сольж засварын ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн. Ажлын гүйцэтгэл-100%



Нийслэлийн шуурхай удирдлагын газраас ирүүлсэн үүрэг даалгаврын дагуу Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороо, Хүннү молл төвийн авто замын урд хэсэгт үүссэн эзэмшигч хариуцагч тодорхойгүй таггүй худгийг зориулалтын таг, суурийг шинээр худалдан авч суурилуулж ажилласан. Ажлын гүйцэтгэл-100%



Төсөл гүйцэтгэгч	Хан-Уул зам засвар арчлалт
Ажлын нэр	Худгийн таг солих
Байршил	Хан-Уул дүүрэг 4-р хороо
Огноо	2024.04.02




Төсөл гүйцэтгэгч	Хан-Уул зам засвар арчлалт
Ажлын нэр	Худгийн таг солих
Байршил	Хан-Уул дүүрэг 4-р хороо
Огноо	2024.04.02



Төсөл гүйцэтгэгч	Хан-Уул зам засвар арчлалт
Ажлын нэр	Худгийн таг солих
Байршил	Хан-Уул дүүрэг 4-р хороо
Огноо	2024.04.02

1.3 Авто замын цэвэрлэгээ үйлчилгээ хариуцаж ажилласан тухай

Хан-Уул дүүргийн 11, 22 дугаар хороо, Их тэнгэрийн амны уулзвараас Яармагийн гүүр хүртэлх 6.2км урт 85,400м² хатуу хучилттай авто зам, дугуйн зам болон явган зам талбай, авто замын нуухны цэвэрлэгээг 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдөр хүртэл тусгай зориулалтын механизм-3, давс цацагч машин-2, цас үлээгч-3, зам шүүрдэгч машин-1, зам талбайн үйлчлэгч-6, зам талбайн мэргэжилтэн-1, хариуцан ажиллаж 1 сард 9 удаагийн давтамжтайгаар нийтийн эзэмшлийн зам талбай, авто зам, гудамж зам талбайн хальтаргаа гулгаа, цэвэрлэгээ үйлчилгээг бүрэн хариуцаж ажилласан. Тус авто замын цэвэрлэгээ үйлчилгээг Хан-Уул дүүргийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг хангаж 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс “Хан-Уул агро” ОНӨААТҮГ-т шилжүүлж хүлээлгэн өгсөн.



ХОЁРДУГААР БҮЛЭГ: “ОЛОН НИЙТИЙН АРГА ХЭМЖЭЭ”

2.1.1 Олон нийтийн арга хэмжээний хүрээнд

“Хоггүй Хан-Уул аян”-ы хүрээнд “Халтиргаа гулгаанаас хамтдаа сэргийлье” уриан дор явган зам талбайн цас мөсийг цэвэрлэх бүх нийтийн ээлжит их цэвэрлэгээ 2024 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 10:00 цагаас 12.00 цагийн хооронд зохион байгуулагдсан. Тус арга хэмжээний хүрээнд 24 ажилтан алба хаагчдын бүрэлдэхүүнтэй хариуцан ажиллаж буй авто замын нуух, явган замын нийт 450м² талбайн мөс, хог хаягдлыг цэвэрлэж иргэдийн эрүүл аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлж ажилласан.



Хан-Уул дүүргийн “Хоггүй Хан-Уул 2024 аян” хүрээнд нийт 60 минутын хугацаанд нийтийн эзэмшлийн зам талбай, явган хүний зам талбайн цас мөс, эзэмшил газрын 50 метр хүртэлх талбайн хог хаягдлыг 12 ажилтан алба хаагчийн хамт 8 шуудай, 100 кг хог хаягдлыг цэвэрлэж ажилласан.




Хан-Уул дүүргийн 9 дүгээр хороо, Ерөнхий боловсролын 114 дүгээр сургуулийн гадна байрлах эвдэрсэн авто замын төмөр хайс хашлагыг засварлах ажлыг хийж гүйцэтгэсэн.



"Тэр бум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо, Айцын аманд нийт 10ш мод, ажилтан тус бүр өөрийн эзэмшлийн газруудад мод тарьж нийт 26ш мод шинээр тарьж ажилласан.



Хан-Уул дүүргийн Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран Амьдрах ухаан, санхүүгийн боловсрол, иргэний эрх зүй, улс төрийн боловсрол танхимын сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад нийт 33 албан хаагчид хамрагдаж сэдвийн хүрээнд ойлголт мэдээлэл бүрэн дүүрэн авсан.



Тус байгууллагын ажилчдын стресс, сэтгэлзүйн байдлыг тодорхойлох түүнийг бууруулах зорилготой “Өөрийгөө сонсож ойлгох цаг” сэдэвт сэтгэлзүйн сургалтыг Тэвэр дүүрэн сэтгэл ТББ-тай хамтран зохион байгуулсан. Сургалтад байгууллагын нийт 33 ажилтан албан хаагчид бүрэн хамрагдсан. Сургагч багшаар тэвэр дүүрэн сэтгэл ТББ-ын багш сэтгэл зүйч Б.Батчимэг ажиллаж тухайн сургалтын хүрээнд өөрсдийн стрессийн түвшнийг тодорхойлж, стрессээс өөрийгөө чөлөөлөх талаар мэдлэг олж авсан сургалтыг зохион байгуулсан.



Байгууллагын нийт ажилчдыг ажлын байранд аваар осолгүй ажиллах, ХАБЭА-н талаар ойлголттой болох зорилгоор Менежментийн зөвлөх үйлчилгээ, ХАБЭА-н сургалт судалгааны “Ололт амжилт” ХХК-тай хамтран байгууллагын нийт ажилчдад зориулсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 12 цагийн сургалтыг 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулж 34 ажилчдыг хамруулж ажилласан.



“Хаврын их цэвэрлэгээ аяны” хүрээнд Их тэнгэрийн амны уулзвараас Яармагийн гүүр хүртэлх авто зам, авто замын нуух, явган зам талбайн хог хаягдалыг цэвэрлэх бүх нийтийн ээлжит их цэвэрлэгээ 2024 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 10:00 цагаас 13:00 цагийн хооронд зохион байгуулагдсан. Тус арга хэмжээний хүрээнд 36 ажилтан алба хаагчдын бүрэлдэхүүнтэй хариуцан ажиллаж буй авто замын нуух, явган замын нийт 1250м2 талбайн хог хаягдлыг цэвэрлэж иргэдийн эрүүл аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлж ажилласан.



Хан-Уул дүүргийн хэмжээнд “Шарилжгүй Улаанбаатар” уриа дор шарилж, хөл газрын ургамлыг цэвэрлэх бүх нийтийн ээлжит их цэвэрлэгээг 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 09.00 цагаас 12.00 цагийн хооронд зохион байгуулсан. Тус арга хэмжээний хүрээнд өөрийн байгууллагын хариуцсан байгууллагын Маршлын гүүрнээс-Яармагийн гүүр хүртэлх 6,2км автобусны буудал, явган зам, дугуйн зам, шарилж, хөл газрын ургамал шарилж устгал болон түүвэр хогийг тусгай зориулалтын авто замын нуухны машин-1, зам талбайн үйлчлэгч-6, бусад ажилтан-8 нийт 14 хүний бүрэлдэхүүнтэй цэвэрлэж ажилласан.



Нийслэлийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг хангаж “Улаанбаатар марафон-2024” арга хэмжээний хүрээнд Хан-Уул дүүргийн Засаг даргын удирдамжийн дагуу нээлт болон эрүүл мэндийн 5км зайн гүйлтэд ажилтан, албан хаагчдыг идэвхтэй хамруулж оролцсон.



ГУРАВДУГААР БҮЛЭГ “ГАМШИГ, ОНЦГОЙ НӨХЦӨЛД АЖИЛЛАХ”

3.1 Гамшиг онцгой нөхцөлд ажилласан тухай

Нийслэлийн нутаг дэвсгэрт үргэлжлэн орсон их борооны улмаас Хан-Уул дүүргийн 8 дугаар хороо, Дэнжийн 10, 11 дүгээр гудамжны залгаа болон өргөн хэсэгт гудамжны зам, талбайн хөрс усанд угаагдан хагарч, гуу жалга үүсэж иргэд аюулгүй зорчиход хүндрэлтэй нөхцөл байдал үүсэн. Иймд Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/510 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж үерийн дараах хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг манай байгууллага зохион байгуулж ажилласан. Тус ажлын хүрээнд 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс тус хорооны Дэнжийн 10, 11 дүгээр гудамжинд бохир хайрга дайргаар засварлаж нийт 60 рейс тээвэрлэж автогрейдер-1, Ачааны машин-1, Доргиурт булт индүү-1, Дугуйт экскаватор-1 нийт 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр тус ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн.



Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо, Барилгачдын гудамжны зам, талбайн хөрс усанд угаагдан хагарч, гуу жалга үүсэж иргэд аюулгүй зорчиход хүндрэлтэй нөхцөл байдал үүсэн. Иймд Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А/423 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж үерийн дараах хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг манай байгууллага зохион байгуулж ажилласан. Тус ажлын хүрээнд 2024 оны 09 дүгээр сарын 22, 23, 24-ний өдрүүдэд тус хорооны Барилгачдын гудамжинд бохир хайрга дайрга болон зохист найрлагатай хайргаар засварлаж нийт 32 рейс тээвэрлэж автогрейдер-1, Ачааны машин-1, Доргиурт булт индүү-1, Дугуйт экскаватор-1 нийт 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр тус ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн.



Хан-Уул дүүргийн Онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг 2024 оны 08 дугаар сарын 01-ны өдрийн 12:00 цагаас 08 дугаар сарын 02-ны өдрийн 00:00 цаг хүртэлх хугацаанд Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбоотойгоор Хан-Уул дүүргийн 14-р хорооны нутаг дэвсгэрт байрлах түргэний голын далан сэргээх, голын ус эргээс хальж гүүрэн байгууламжыг даван урссан хэсгийн голдирол залах ажлыг экскаватор-1ш, ковш-1ш, автогрейдер-1ш нийт 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр хийж гүйцэтгэсэн.



2023 оны 08 дугаар сарын 10-ны өдөр Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах Хапитат замын далан усанд идэгдэж тээврийн хэрэгсэл зорчих боломжгүй болсон байсан тул хайргаар дүүргэн засварлах ажлыг автогрейдер-1ш нийт 2 хүний бүрэлдэхүүнтэйгээр хийж гүйцэтгэсэн.

